

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН МӨНХЖАРГАЛЫН МЭНДЭЭГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн тувшин			Эхэлсэн, дүүссэн хугацаа	Биелэлти йн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт		
1	2	3	4	5	6	7	
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							

Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

1.	Арга хэмжээ 2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллах /AX-2050 - 2.3.3, ЗГУАХ 2024-2028 - 2.1.1.23/	Хуулийн төсөл /тоо/	0	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслүүдийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлын хүрээнд холбогдох судалгаа, хэлэлцүүлгийг зохион байгуулахад хамтран ажилласан. Мөн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдах “хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тогтолцоо” бүлгийн агуулгыг боловсруулахад чиглэсэн ажлын хүрээнд хамтран ажиллаж байна.	01-06	70
		Дагалдан гарах хуулийн төсөл /тоо/	0	20			
		Засгийн газрын хуралдааны тэмдэглэл /тоо/ Хуулийн төсөл /тоо/	0	1			
2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУССАН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР							

Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах

2.	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын төслийг боловсруулахад хамтран ажиллах	Зураглал /тоо/	0	0	Хуулийг эхийн хэвлэйд бүрэлдэхээс эхлээд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, үнэлэх, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн тогтолцоог оновчтой бүрдүүлэх	01-06	90
----	---	----------------	---	---	---	-------	----

					асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, амьдралын туршид нь нийгмийн хамгааллын нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулсан. Үйлчилгээний зураглалын төслийг Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох төлөөлөлд танилцуулсан. Зураглалын эхний хувилбарыг 5 сарын 22-ны өдөр Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны холбогдох албан хаагчдад танилцуулан саналыг тусгав. Мөн 5 сарын 26-ны өдөр Төрийн бус байгууллагуудын төлөөлүүдэд танилцуулан санал авах уулзалтыг зохион байгуулав		
	Дэд арга хэмжээ 4.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний ерөнхий зураглал боловсруулахад 0-18 насын хүүхдэд нийгмийн хамгааллын чиглэлээр тусгах санал боловсруулах	Боловсруулсан санал	0	0	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд хүргэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээний ерөнхий зураглалыг боловсруулах ажлын хүрээнд 0-18 насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах, хууль журамд тусгах саналуудыг боловсруулахад өөрийн эрхэлсэн чиг үүргийн хүрээнд хамтран ажилласан. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг хангах зорилгоор санал боловсруулж ажилласан. Үүнд: Нийгмийн хамгааллын асуудлаар:</p> <ul style="list-style-type: none"> • 0-18 насын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нийгмийн хамгааллын үйлчилгээг шатлалжуулах, талаар санал боловсруулсан • Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний ерөнхий зураглалыг хэрэгжүүлэн ажиллахад шаардлагатай хуулийн зохицуулалтуудыг тусгах 	01-06	90

					<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлчилгээг Картын системээр олгох тогтолцоог бий болгох Сургалт, сурталчилгаа нэлэөллийн ажлыг бүх шатанд зохион байгуулах Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч гэр бүлийн гишүүдэд чиглэсэн халамж, дэмжлэгийн арга хэмжээ болон дэмжих тогтолцоог бий болгох Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд болон зөвлөн туслах, зохицуулагч төрийн бус байгууллагыг тогтворжуулах, чадавхжуулах талаар асуудлуудыг тусгасан. 		
3.	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршихад хамтран ажиллах /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.25/	Туршилт хийх аймаг, дүүрэг /too/	0	0	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, нийгмийн үйлчилгээг хэрэгцээнд нь нийцүүлэн үзүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох, олон улсын аргачлалын дагуу үнэлэх, туршилтыг зохион байгуулах, судалгаа хэлэлцүүлгийн ажлыг эхлүүлэхээр салбар дундын уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уулзалт нь ICF-ыг үндэсний хэмжээнд ашиглах боломж, өнөөгийн нөхцөл байдал, салбар дундын хамтын ажиллагааг тодорхойлох зорилготой эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хөгжлийн бодлогын салбарын төлөөлөл, судлаачид, мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан.</p> <p>Уулзалтын үеэр ICF-ыг одоогоор ашиглаж буй байгууллагуудын туршлага, хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Аргачлалыг турших ажлын хүрээнд хамтран ажиллах боломжтой гол салбарууд, хамтрагч талуудын оролцоо, үүргийн талаар мэдээлэл солилцов - Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үнэлэх, нийгмийн үйлчилгэээд холбох, чадамжид суурилсан хандлагыг 	01-06	70

						төлөвшүүлэхэд ICF аргачлалыг ашиглах үндэсний загвар аргачлалыг туршихад шаарлагатай ажлын хэсэг байгуулан ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна.		
4	Арга хэмжээ 4.3. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах	Үйл ажиллагаа явуулах төв /тоо/	4	7	Xөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний хөгжлийг дэмжих, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн хөгжлийг дэмжих төвүүдийг Аймаг, нийслэлийн түвшинд хэрэгжүүлж болохуйц нөхцөл байдал, чадавх хэрэгцээнд суурилсан загвар төвүүдийг байгуулан үйл ажиллагааг явуулж болох удирдамжийн төсөл боловсруулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлж ажилласан.	01-06	90	
	Дэд арга хэмжээ 4.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, баттуулах	Дүрэм /тоо/	1	1	Xөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28.1 дэхь заалт, Боловсролын тухай хуулийн 17.9 дэхь заалтуудын хүрээнд Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 сарын 21-ний өдрийн A/85, A/55, A/49 хамтарсан тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм"-ийг баталсан. Төвийн дүрмийг боловсруулах ажлын хэсгийн 3 удаагийн уулзалтад оролцож хурлын үеэр боловсруулж буй дүрмийн тесөлд өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд санал хүргүүлж засвар, намэлт санал боловсруулан Боловсролын яаманд хүргүүлсэн. Үүнд: Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний уялдаа холбоо, хэрэгцээнд суурилсан дэмжлэг үзүүлэх үйлчилгээний талаар санал боловсруулсан. Нийгмийн хамгааллын асуудлаар тусгайллан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, нийгмийн халамжийн талаар болон хамтарсан багийн оролцооны асуудлаар санал тусгасан.	01-03	90	
	Боловсруулсан санал /тоо/		1	1	Xөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий	03-06	100	

	Дэд арга хэмжээ 4.3.2 "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааны удирдамжид хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээний чиглэлээр тусгах санал боловсруулах				дэмжих төвийн үйл ажиллагааны удирдамж, үнэ тарифын төслийг төрийн бус байгууллагын төлөөллүүдтэй хамтран боловсруулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүргүүлсэн. Удирдамжид дэмжих төв нь З төрлийн үйлчилгээний талаар туссан бөгөөд үүнээс хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээн нь 5 төрлийн үйлчилгээни чиглэлээр санал тусгасан. Үүнд: Хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээ нь хүүхдийн нас, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон нийгэмшүүлэх, танин мэдэх, бие махбодын хөгжлийг дэмжсэн эрүүл аюулгүй орчинд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амраах зэрэг дараах үйлчилгээг үзүүлж болно: <ul style="list-style-type: none">- Асрах, сувилах үйлчилгээ;- Хүүхдийн сэтгэл зүйн зөвлөгөө;- Асран хамгаалагчдад зориулсан сургалт, зөвлөгөө;- Олон нийтийн арга хэмжээ- Хүүхдэд үзүүлэх бусад үйлчилгээ /тогоюомон засал, хөгжим засал/		
	Дэд арга хэмжээ 4.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааг орон нутагт байгуулах чиглэлээр ХБХЭМБНХ-ын салбар комиссыг арга зүйгээр хангах	Хэрэгжилтийн хувь	-	50%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөгжлийг дэмжих үйлчилгээг хүргэх дэмжих төвийн тогтолцоог аймаг, нийслэлд хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ХБХЭМБНХ-уудыг арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаанд хамтран ажилласан. Хэнтий аймаг, Сүхбаатар аймаг, Дундговь аймаг, Өмнөговь аймаг, Говьсүмбэр аймаг, Дорнговь аймгуудад зохион байгуулагдсан арга хэмжээ, сургалтуудад дэмжих төвийн талаар мэдээлэл хүргэж ажилласан. Мөн 21 аймаг 9 дүүргийн ХБХЭМБНХСК-уудын нарийн бичгийн дарга нарт дэмжих төвийн талаар цахимаар мэдээлэл өгсэн.	05-06	90
5.	Арга хэмжээ 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг	Засгийн газрын тогтоолын төсөл /тоо/;	-	-	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"- ийг шинэчлэн боловсруулж төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн хэлэлцүүлэг	01-06	70

	шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх				зохион байгуулж, дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн ажиллаж байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлахаар ажлын даалгаврыг боловсруулж байна.		
	Дэд арга хэмжээ 4.4.1 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төслийг боловсруулж холбогдох төрийн болон ТББ, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулах	Дүрмийн төсөл	-	1	Zасгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм" нь 9 бүлэг 107 заалтаас бүрдэж байсан бөгөөд комиссын шийдвэр гаргах уйл ажиллагааны талаар болон төв болон салбар комисс, дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, тавигдах шаардлага, томилж, чөлөөлөх талаар, салбар комиссын бүрэлдэхүүнд ажиллах байгууллагын нийтлэг чиг үүргийн талаарх заалтуудыг тусгах шаардлагатай байгаа саналуудыг үндэслэн 11 бүлэг 136 заалт бүхий дүрмийг төслийг боловсруулсан. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулсан. Үүнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ ууд болон 21 аймаг 9 дүүргийн салбар комиссуудыг хамруулсан. Ирүүлсэн саналыг Төрийн болон ТББ, салбар комиссуудын ирүүлсэн санал, нэмэлт санлуудыг ангилан нэгтгэж дүрмийн төсөлд тусгасан.	02-05	70
	Дэд арга хэмжээ 4.4.2. ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцүүлэг /too/	-	2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн төсөл танилцуулах хэлэлцүүлгийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, салбар комиссын гишүүд болон төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдийг оролцуулан 2 удаа зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээний удирдамж болон комиссын дүрэмд ICF-ийг тусган чиглэлээр зөвлөх үйлчилгээний удирдамжийн төслийг боловсруулж байна.	04-09	70

	Дэд арга хэмжээ 4.4.3 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийг төсөлд яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулах	Санал /тоо/	-	-	Хугацаа болоогүй		
--	---	-------------	---	---	------------------	--	--

Зорилт 7: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах

6.	Арга хэмжээ 7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах,	Хэрэгжилтийн хувь	71	40	<p>Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний жагсаалтыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн ичгийн даргын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулан батлуулсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны хүрээнд дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр "Түгээмэл хөгжил" ТББ-тай хамтран ГБХНХЯ-ны барилгын гадна болон дотор орчны байдалд хүртээмжийн үнэлгээг хийсэн.</p>	01-06	100
7.	Арга хэмжээ 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	40	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2025 оныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарлаж "ХАМГИЙН САЙН ХАЛАМЖ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ" гэсэн зорилт дэвшүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн нээлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд цогц арга хэмжээг 2025 оны 05 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулсан. Дундговь аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалдаг эцэг эхчүүдийн эрхэлж буй бизнесийг сурталчлах, дэмжих, төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос хүргэх "Ability expo" арга хэмжээг зохион байгуулж, Дундговь аймгийн 15 сум, 68 багаас 350 орчим хүн оролцсон.</p>	03-06	100

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

Зорилт 1."Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог хангах" зорилтын хүрээнд

	Арга хэмжээ 1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	-Хэрэгжилтийн хувь	100%	50%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд урлаг спортоор дамжуулан нийгэмшүүлэх хүрээнд сонор микротиа холбоо ТББ-аас ирүүлсэн Хүүхэлдэйн жүжиг зохион байгуулах үйл ажиллагаанд санхүүжилт олгох удирдамжийн төслийг боловсруулан ажиллаа. Мөн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний жагсаалтыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн ичгийн даргын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулан ажиллаж байна.	01-06	80
8.	Арга хэмжээ 1.2. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хоёрдогч хундрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	Тархины саа саажилт, аутизм, уналт таталт, оюуны бэрхшээл, усжилт, уйланхай, даун оноштой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоо, шинжилгээг санаачлан зохион байгуулж байгаа Эрхэм нандин сувд ТББ-ын үйл ажиллагааг дэмжин ажиллаж 2025 оны эхний хагас жилийн байдлаар хөдөө орон нутгийн 378 хүүхэд, нийслэлийн 78 хүүхэд нийт 456 хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.	05-06	100
	Дэд арга хэмжээ 1.2.1. 21 аймийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч нэгтгэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	100%	2025 оны 03 дүгээр сарын 1-нээс 2025 оны 04 дүгээр сарын 1 хуртэл 21 аймаг 9 дүүргийн ХБХЭМБНХСК-оос үзлэгт хамрагдах 630 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийг авч нэгтгэсэн байна.	05-06	100
	Дэд арга хэмжээ 1.2.2. Судалгааны нэгтгэлд үндэслэн хуваарь гарган эрүүл мэндийн үзлэгийг хамтран зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	50%	Судалгаанд үндэслэн үзлэгийг 2025 оны 05 дугаар сарын 03-05 дугаар сарын 24-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Үзлэг, оношлогооны үр дүнд: <ol style="list-style-type: none">Хөдөө, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй 378 хүүхдийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулж, эрт үед шаардлагатай эмчилгээ үйлчилгээнд хамруулсан.Чиг гутал" ХХК-аас "Гоё мөрөө үлдээ" сайн үйлсийн аяны хүрээнд 100ш хөлийн чиг баригчийг үнэ төлбөргүй бэлэглэж, хүүхэд бүрт тааруулж егсэн.ЭХЭМҮТөвийн болон АНУ-ын мэдрэлийн мэс заслын эмч нарын	06	100

					хамтарсан үзлэгт орон нутгийн 20 хүүхдийн хамруулж, цаашид хийгдэх эмчилгээний чиглэлийг өгсөн. 4. 6 дугаар сарын 10-ны өдөр ГССҮТ дээр БНЭУ-ын мэдрэлийн мэс заслын эмч нарын хамтарсан үзлэгт шаардлагатай хүүхдүүдийг хамруулахаар болсон.		
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 2 "Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг илрүүлэх, үнэлэх, тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулах төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх"

9	Арга хэмжээ 2.1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, хүнд хэлбэрийг тодорхойлох ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Сайдын тушаалын /too/;	1	1	2025 онд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг оновчтой хүргэх чиглэлээр тусгагдсан заалтуудын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн A/807, A/216 тоот хамтарсан тушаалаар баталсан Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтээс хүнд хэлбэрийн өвчин гэмтлийг ялган тодорхойлох ажлын хэсгээс боловсруулсан жагсаалтын төсөлд ТББ, салбар комиссуудаас саналыг авч нэгтгэн боловсруулсан.	01-06	90
	Дэд арга хэмжээ 2.1.1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, хүнд хэлбэрийг тодорхойлох ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	80%	Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтээс хүнд хэлбэрийн өвчин гэмтлийг ялган тодорхойлох ажлын хэсгээс боловсруулсан жагсаалтын төсөлд ТББ, салбар комиссуудаас саналыг авч нэгтгэн боловсруулсан.	01-03	80
	Дэд арга хэмжээ 2.1.2. ХБХЭМБНХ-ын салбар комисс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцуулэг /too/	-	2	Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг Төрийн бус байгууллага, 21 аймаг, салбар комиссын гишүүдэд 2 удаагийн цахим хуралыг зохион байгуулахад нэмэлт саналыг нэгтгэх ажлыг зохион байгуулсан.	03	90

	Дэд арга хэмжээ 2.1.3 Байнгын асаргааны тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	80	Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Жагсаалт шалгуур үзүүлэлт батлах тухай А/807, А/216 тушаал"- д нэмэлт оруулж Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/68, А/62 дугаар хамтарсан тушаалаар "Байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур"-ыг баталсан. ХБХЭМБНХСК-ууд дээрх өвчин гэмтлийн жасгаалтаар хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг магадлан ажиллахад өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамтран ажилласан.	01-06	90
10	Дэд арга хэмжээ 2.1.4. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд хяналт, тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх	Хяналт хийсэн тоо	0%	15	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг сайжруулах, хуралд оролцох, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллах зорилгоор нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн хуралд оролцсон. Нийслэлийн дүүргүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо их, 1 удаагийн хурлаар орох хүүхдүүдийн тоо 20-45 хүртэл байсан. Мөн тус хуралд оролцох үеэр байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн хүнд хэлбэрийг тодорхойлох ажлыг зохион байгуулж байсан тул ачаалал ихтэй ажиллаж байсан. Хурлаар орох хүүхдийн тоо их байдаг учир 1 хүүхэдтэй ажиллах цага бага, хөгжлийг дэмжих үйлчилгээнд төвлөрөхөөс илүү байнгын асаргааны сунгалтыг хийж гаргадаг алдаа дүүрэг бүрт байсныг тухай бүр анхааруулж зөвлөж ажилласан. 2025 оны 03 дугаар сарын 25-нд Хэнтий аймаг, 03 дугаар сарын 28-нд Сүхбаатар аймагт, 05 дугаар сарын 16-ны өдөр Дундговь аймагт тус тус ажиллаж салбар комиссын хурлуудад оролцсон. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 дүүрэг, 3 аймгийн салбар комиссын хуралд оролцон ажилласан байна.	01-06	90

11	Арга хэмжээ 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах бүсийн сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан салбар комиссын тоо	0	7	Салбар комиссын гишүүдийг нэгдсэн байдлаар чадавхжуулах сургалтыг 2025 онд бүсчилсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2025 оны 05 сарын 16-ны өдөр.govийн бүсийн сургалтыг амжилттай зохион байгуулж сургалтанд Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгийн ХБХЭМБНХСК-ын 25 гишүүн хамрагдсан. Сургалтаар салбар комиссын гишүүдэд Сургалтыг онол, практик хосолсон байдлаар зохион байгуулсан бөгөөд Сургалтанд салбар комиссын үйл ажиллагаа, тайлан мэдээ ирүүлэх маягтын талаар болон цаашид анхаарах асуудлууд сэдвээр мэдээлэл бэлтгэн танилцуулсан. Танхимын сургалтын дараа Дундговь аймгийн салбар комиссын хуралд оролцож туршлага судалсан. 06 сард төвийн бусийн сургалтыг Дархан-уул аймагт Сэлэнгэ, Төв, Дархан-уул аймгуудыг хамруулан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	05-06	100	
Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийн сан бий болгох, иргэдийг мэдээллээр хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах								
12.	Арга хэмжээ 3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын тайлангийн шинэчлэн боловсруулах	Маягт /тоо/	5	4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулах 2025 оны 1 дүгээр улирлын тайланг шинэчилсэн маягтаар авсан.	01-04	80	
13.	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ажиллагаанд ашиглах мэдээллийн санг ашиглалтанд оруулах ажлыг Цахимжилт их өгөгдлийн бодлогын газартай хамтран зохион байгуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50%	20%	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг WWW.CWD.MLSP.GOV.MN Домэйн нэрээр төрийн мэдээлэл солилцооны "ХУР" болон E-Mongolia системтэй холбож, дүүргүүдийн салбар комиссын нарийн бичиг нарт нэвтрэх эрх үүсгэн салбар комиссын ээлжит хуралд туршин ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар мэдээллийн санг бүрэн ашиглахад хүүхдийн мэдээлэл дуудаж байгаа хурд муу байгаа учир сайжруулах шаардлагатай байгаа.	03-06	70	

					Mэдээллийн санг бурэн ашиглалтад оруулахаар Цахим их өгөгдлийн газартай хамтран ажилаж байна.		
14	Арга хэмжээ 3.3. Салбар комиссын улирлын тайланг хуваарийн дагуу хүлээн авч, нэгтгэх, комиссын гишүүдийн урамшууллын тооцооллыг хийж, шийдвэрлүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	50%	2025 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт 21 аймаг, 9 дүүргийн 30 салбар комисс нийт 183 удаа хуралдаж 3123 хүүхдийг хурлаар оруулсан байна. Салбар комиссын урамшуулалд 1 дүгээр улиралд 118,029,501 төгрөгийг төрийн нарийн бичгийн даргын тушаалаар олгосон.	01-06	100

Зорилт 4. "Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд"

					Японы хүүхдийг ивээх сантай хамтран "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насын хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд зөвлөлийн уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл солилцон, цаашид 2025 онд төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон. Мөн төслийн хүрээнд удирдах зөвлөлийн уулзалтыг 2025 оны 04 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж төслийн хүрээнд цаашид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар болон гарын авлагад оруулах мэдээллийг шинэчлэх талаар уулзалтыг хамтран зохион байгуулсан.		
15.	Арга хэмжээ 4.1. Японы хүүхдийг ивээх сантай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насын хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд зохион байгуулж байгаа холбогдох арга хэмжээнд оролцож арга зүйгээр хангаж ажиллах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	100%	50%	2025 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах ажлын Олон улсын уналт таталтын өдрийг угтан мэдээлэл хүргэх постерийг бэлтгэн яамны цахим системд байршуулсан. Мөн Аутизмыг таниулах өдөрлөгт оролцож иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	01-06	90
16	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах; (Олон Улсын эпилепси уналт таталтын эсрэг өдөр)	Арга хэмжээний тоо	2	1	2025 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах ажлын Олон улсын уналт таталтын өдрийг угтан мэдээлэл хүргэх постерийг бэлтгэн яамны цахим системд байршуулсан. Мөн Аутизмыг таниулах өдөрлөгт оролцож иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	04	100

Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд

					Авиалгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;		
17	Арга хэмжээ 5.1. Авиалгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Авиалгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.	01-06	100

18	Арга хэмжээ 5.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна.	100%	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах ажлыг тухай бүр хийж холбогдох хурал, уулзалт, сургалтанд хамрагдан ажиллаж байна.	01-06	100
19	Арга хэмжээ 5.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	2025 оны эхний хагас жил хэлтсийн бичиг хэргийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд 53 албан бичгийг бичиг хэргийн дэвтэрт бүртгэн хуваарьлагдсан бичгийг албан хаагчдад дамжуулах, дотоод саналыг нэгтгэн газар хэлтсүүдэд хүргүүлэх болон үүнээс хариуцах асуудлын хүрээнд 21 албан бичиг, 16 өргөдөл, гомдол хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаа.	01-06	100
20.	Арга хэмжээ 5.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлагнах;	Хугацаанд нь тайлагнасан байна.	100%	100%	Монгол Улсыг хөгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөө"-ний биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, ГБХНХЯ-ны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хэрэгжилт, Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр заасан хугацаанд хэлтсийн албан хаагчдаас авч нэгтгэн гаргаж байна.	01-06	100

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Биелэлтийн хувь
			Сурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/			Эхлэх, дүүсэх хугацаа
			3	4	5	6	7	
	1	2						

23	Арга хэмжээ 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр зохион байгуулахдах дотоод, гадаа хурал уулзалт, сургалт семинарт чиг үүргийн дагуу тогтмол хамрагдах	Хэрэгжилтийн хувь	0	100%	Японы хүүхдийг ивээх сангийн "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насын хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд 2 удаагийн сургалтанд хамрагдсан байна.	01-06	100
24	Арга хэмжээ 3. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	Хэрэгжилтийн хувь	0	100%	Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр яамнаас зохион байгуулж буй бүх төрлийн сургалтад хамрагдсан бөгөөд баасан гариг бүрийн мэдээллийн цагаар зохион байгуулдаг сургалтаас 6 удаагийн сургалтад хамрагдсан байна.	01-06	100

ТАЙЛАН БИЧСЭН:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Мэндээ /..... /

2025 оны ... дугаар сарын ... өдөр

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫНАСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН МӨНХЖАРГАЛ ОВОГТОЙ МЭНДЭЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1	2	3	4	5	
	Оноо	60 хуртэл	10 хуртэл	70 хуртэл	

Зорилт 2. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хуртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

1.	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллах /АХ-2050 - 2.3.3, ЗГУАХ 2024-2028 -2.1.1.23/	42	7	49	49
----	--	----	---	----	----

Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах

2.	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын төслийг боловсруулахад хамтран ажиллах	42	7	49	49
3	Дэд арга хэмжээ 4.1.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний ерөнхий зураглал боловсруулахад 0-18 насны хүүхдэд нийгмийн хамгааллын чиглэлээр тусгах санал боловсруулах	42	7	49	49
	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг туршихад хамтран ажиллах /ЗГУАХ 2024-2028 -2.1.1.25/	42	7	49	49
	Арга хэмжээ 4.3.				

	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг төв, орон нутагт ажиллуулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах	42	7	49	49
4	Дэд арга хэмжээ 4.3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг Боловсролын яам, Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, батлуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.3.2 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааны удирдамжид хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээний чиглэлээр тусгах санал боловсруулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвийн үйл ажиллагааг орон нутагт байгуулах чиглэлээр ХБХЭМБНХ-ын салбар комиссыг арга зүйгээр хангах	42	7	49	49
5	Арга хэмжээ 4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын дүрмийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.4.1 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төслийг боловсруулж холбогдох төрийн болон ТББ, салбар комиссуудаас санал авах ажлыг зохион байгуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.4.2. ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийн төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 4.4.3 ХБХЭМБНХ-ын комиссын дүрмийг төсөлд яамдуудаас санал авах ажлыг зохион байгуулах	42	7	49	49

“Зорилт 7: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах

6.	Арга хэмжээ 7.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах,		60	10	70	70
7.	Арга хэмжээ 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах		60	10	70	70
Зорилт 1."Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог хангах" зорилтын хүрээнд						
8.	Арга хэмжээ 1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;		60	10	70	70
9.	Арга хэмжээ 1.2. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хоёрдогч хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах		42	7	49	49
9.	Дэд арга хэмжээ 1.2.1. 21 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг авч нэгтгэх		42	7	49	49
9.	Дэд арга хэмжээ 1.2.2. Судалгааны нэгтгэлд үндэслэн хуваарь гарган эрүүл мэндийн үзлэгийг хамтран зохион байгуулах		42	7	49	49
Зорилт 2 "Хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг илрүүлэх, үнэлэх, тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгт хамруулах төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх"						
10.	Арга хэмжээ 2.1. Байнгын шаардлагатай хэлбэрийн бэрхшээлтэй тодорхойлох халамжийн зорилтолт хүүхдэд ажлыг зохион байгуулах	асаргаа хүнд хөгжлийн хүүхдийг нийгмийн тэтгэмжийг хүргэх	42	7	49	49
10.	Дэд арга хэмжээ 2.1.1. Байнгын шаардлагатай бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, хүнд хэлбэрийг тодорхойлох ажлын хэсгийн үйл	асаргаа хөгжлийн хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, хүнд хэлбэрийг тодорхойлох ажлын хэсгийн үйл	42	7	49	49

	ажиллагаанд дэмжлэг үзүүлэх				
	Дэд арга хэмжээ 2.1.2. ХБХЭМБНХ-ын салбар комисс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 2.1.3 Байнгын асаргааны тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	42	7	49	49
	Дэд арга хэмжээ 2.1.4. Аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд хяналт, тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх	42	7	49	49
11	Арга хэмжээ 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах бүсийн сургалт зохион байгуулах	60	10	70	70
Зорилт 3: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийн сан бий болгох, иргэдийг мэдээллээр хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах					
12.	Арга хэмжээ 3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын улирлын маягтыг шинэчлэн боловсруулах	42	10	52	52
13.	Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ажиллагаанд ашиглах мэдээллийн санг ашиглалтанд оруулах ажлыг Цахимжилт их өгөгдлийн бодлогын газартай хамтран зохион байгуулах	42	7	49	49
14.	Арга хэмжээ 3.3. Салбар комиссын улирлын тайланг хуваарийн дагуу хүлээн авч, нэгтгэх, комиссын гишүүдийн урамшууллын тооцооллыг хийж, шийдвэрлүүлэх	60	10	70	70
Зорилт 4. "Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд"					
15.	Арга хэмжээ 4.1. Японы хүүхдийг ивээх сантай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "Тэгш хүртээмжтэй цогц	60	10	70	70

	Үйлчилгээгээр бага насын хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд зохион байгуулж байгаа холбогдох арга хэмжээнд оролцож арга зүйгээр хангаж ажиллах				
16.	Арга хэмжээ 4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах; (Олон Улсын эпилеспи уналт таталтын эсрэг өдөр)	60	10	70	70
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд					
17.	Арга хэмжээ 5.1. Авшын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	60	10	70	70
18.	Арга хэмжээ 5.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах	60	10	70	70
19.	Арга хэмжээ 5.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	60	10	70	70
20.	Арга хэмжээ 5.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлагнах;	60	10	70	70
Дундаж оноо:					

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1 2 3 4
1	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр зохион байгуулахдах дотоод, гадаа хурал уулзалт, сургалт семинарт чиг үүргийн дагуу тогтмол хамрагдах	100	25	15
2	Арга хэмжээ 2.			

	Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	100	15	15
	Дундаж оноо		15	15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	6	6
3.	Асуудал шийдвэрлэх	6	6
4.	Хариуцлагатай байдал	6	6
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
	Дундаж оноо	6,4	6,4

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
		1
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
	Дундаж оноо	8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	60,7 60,7 56,9
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,4 6,4
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
	Нийт оноо =	90,1 90,1

Үнэлгээ өгсөн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга

Нэгжийн дарга

(С.Рэгзэн)

86.3.
гоод олон
өдөр

2025.06.13 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн
хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

Төрийн жинхэнэ албан хаагч:

.....М.М. (М.Мэндээ)

2025.06.13. (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....В.Т. (В.Түвшинжаргал)
2025.06.20 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөцийн асуудал
хариуцсан шинжээч

.....Б.Б. (Б.Баянжаргал)
2025.06.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
яамны Төрийн нарийн бичгийн дарга

Төсвийн шууд захираач

.....Л.М. (Л.Мөнхзул)
2025.06.20 (огноо)

